



**Н.НЯМДАВААГИЙН НЭРЭМЖИТ  
ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН  
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН  
ТУШААЛ**

2020 оны 03 сарын 02 өдөр

Дугаар 2/24

Улаанбаатар хот

**Хүний нөөцийн сонгон шалгаруулах  
журам батлах тухай**

Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.10.6 дахь заалт, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.6.1 дэхь заалт, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалт, Монгол улсын засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан "Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт"-ийн хавсралтын 2 дугаар зүйлийн 2.5 дахь хэсэг, "Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн бүтэц үйл ажиллагаа"-ны 6.3 дахь хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/155 дугаар тушаалаар батлагдсан Хавдар судлалын үндэсний төвийн дүрмийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Хавдар судлалын үндэсний төвийн хүний нөөцийн сонгон шалгаруулалтын журмыг нэгдүгээр хавсралтаар, сонгон шалгаруулалтад орох хүсэлт гаргасан иргэдийн бичиг баримтын бүртгэлийг хоёрдугаар хавсралтаар, сонгон шалгаруулалтын үнэлгээний хуудсын маягтыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү журмыг 2020 оны 3 дугаар сарын 02-ны өдрөөс хэрэгжүүлж ажиллахыг хүний нөөц, хөгжлийн албаны дарга (Д.Мөнхтуяа)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, хөгжил эрхэлсэн дэд захирал (Л.Баярсайхан)-д даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Хавдар судлалын үндэсний төвийн захирлын 2009 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 51 дугаартай тушаал хүчингүй болсонд тооцсугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Н.ЭРДЭНЭХҮҮ



Н.Нямдаваагийн нэрэмжит Хавдар судлалын үндэсний төвийн  
ерөнхий захирлын 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн  
А/27 дугаар тушаалын Нэгдүгээр хавсралт

## ХҮНИЙ НӨӨЦИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЖУРАМ

### Зорилго

Энэхүү журмын зорилго нь Хавдар Судлалын Үндэсний Төв (ХСҮТ)-ийн дүрэмд заасан зорилт, зорилгыг хэрэгжүүлэх үүрэг бүхий өндөр мэдлэг, ур чадвартай эрүүл мэндийн ажилтныг сонгон шалгаруулах ажлыг оновчтой зохион байгуулах, ажил олгогч, ажил горилогчийн хоорондын харилцааг зохицуулах замаар төвийн хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэхэд оршино.

### I БҮЛЭГ ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

#### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.10.6 дахь заалтад "эмнэлгийн дэд захирал болон зохион байгуулалтын нэгжийн удирдлагыг сонгон шалгаруулах журмыг батлах", Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.6.1 дэхь заалтад "эмнэлгийн захирал нь эмнэлгийн дэд захирал болон зохион байгуулалтын нэгжийн удирдлагыг сонгон шалгаруулж, томилох", Монгол улсын стандарт MNS 6330:2017 "Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн бүтэц үйл ажиллагаа"-ны 6.3-д Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт ажиллах эрүүл мэндийн ажилтан нь "Хүний нөөцийг бүрдүүлэхэд тухайн ажлын байранд тавигдах шаардлагыг хангасан нэр дэвшигчийг байгууллагын дотроос болон гаднаас ил тод сонгон шалгаруулж ажилд авна" гэснийг үндэслэж энэхүү журмыг боловсруулсан болно.
- 1.2 Энэхүү журмаар зохицуулагдаагүй харилцааг "Эрүүл мэндийн тухай хууль", "Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль", "Хөдөлмөрийн тухай хууль", "Төрийн албаны тухай хууль", Хавдар судлалын үндэсний төвийн дүрэм, Хөдөлмөрийн дотоод журам болон холбогдох бусад эрх зүйн актуудыг үндэслэл болгон зохицуулна.
- 1.3 Төвийн батлагдсан орон тоо сул чөлөөтэй болсон, шинээр орон тоо бий болсон үед ажилтан авч ажиллуулах, мөн үндсэн ажилтан хөдөлмөрийн гэрээ дуусгавар болоогүй бөгөөд түүний ажил, албан тушаал хөдөлмөрийн тухай хуулийн 35 дугаар зүйл, Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлд заасны дагуу 3 сараас дээш хугацаагаар хадгалагдсан үед оронд нь хугацаатай гэрээгээр ажилтан авч ажиллуулахад энэ журмыг баримтлан хүний нөөцийн бүрдүүлэлтийг хийнэ.

## Хоёр. Журмын нэр томъёоны тодорхойлолт

- 2.1. "Ажил олгогч" гэж Хөдөлмөрийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэхь заалтад заасан хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажилтан авч ажиллуулж байгаа этгээдийг;
- 2.2. "Ажилтан" гэж Хөдөлмөрийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтад заасан ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байгаа иргэнийг;
- 2.3. "Сонгон шалгаруулах комисс" гэж энэ журмын -д батлагдсан сонгон шалгаруулалтыг явуулах орон тооны бус комисс буюу нэрлэгдсэн албан тушаалтнуудыг;
- 2.4. "Ажил горилогч" гэж тухайн сонгон шалгаруулалт зарласан ажлын байранд шаардлагуудыг ханган өрсөлдөх хүсэлт гаргасан иргэнийг;
- 2.5. "Хөдөлмөрийн гэрээ" гэж Хөдөлмөрийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-д заасан нэг талаас ажилтан нь ажил олгогчоос хуульд нийцүүлэн тогтоосон хөдөлмөрийн дотоод журмын дагуу тодорхой ажил гүйцэтгэх, нөгөө талаас ажил олгогч нь ажилтанд хөдөлмөрийн үр дүнд тохирсон цалин хөлс олгох, хууль тогтоомж болон хамтын гэрээ, хэлэлцээрт заасан хөдөлмөрийн нөхцлөөр хангах тухай харилцан үүрэг хүлээсэн тохиролцоог хэлнэ.

## Гурав. Баримтлах зарчим

- 3.1 **Ажил олгогч** болон түүнийг төлөөлж буй этгээд нь;
  - 3.1.1 Сонгон шалгаруулалтад оролцогчдод нэгэн ижил мэдээлэл өгөх ба эрх тэгш оролцох боломжоор хангана.
  - 3.1.2 Сонгон шалгаруулах үйл явцад хувийн ашиг сонирхлоор үнэлж, дүгнэхийг хатуу хориглоно.
  - 3.1.3 Ёс зүйг чанд баримтлан, шударга, ил тод, тэгш хандах болон нээлттэй, өрсөлдөөний зарчмыг удирдлага болгон бусдын нөлөөлөлд автахгүй энэхүү журмыг мөрдөж ажиллана.
  - 3.1.4 Ажил горилогчдод дарамт шахалт үзүүлэхгүй, байгууллагын талаар сөрөг ойлголт өгөхгүй байх тал дээр анхаарч хүндэтгэлтэй харилцана.
- 3.2 **Ажил горилогч нь**;
  - 3.2.1 Ажил олгогч болон түүнийг төлөөлж буй этгээдэд хууль бусаар нөлөөлж, өөрт давуу байдал бий болгохгүй байна.
  - 3.2.2 Ажил олгогч болон түүнийг төлөөлж буй этгээд, бусад өрсөлдөгчдөд хүндэтгэлтэй хандаж, ёс зүйг чанд баримтлана.
  - 3.2.3 Хүний нөөцийн бүрдүүлэлтийг гадаад болон дотоод эх үүсвэрээс бүрдүүлэх ба ХСҮТ-ийн дотоод нөөц давуу эрхтэй байна.

## II БҮЛЭГ

### АЖЛЫН БАЙРАНД ШИНЭЭР АЖИЛД АВАХ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ

#### Дөрөв. Сонгон шалгаруулалтыг зарлах

- 4.1 ХСҮТ-ийн хүний нөөц, хөгжлийн алба (цаашид "ХНХА" гэх) сул чөлөөтэй буюу эзгүй ажлын байрны мэдээллийг төвийн цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгсэл, ажлын байрны нэгдсэн сүлжээгээр 14 хоногийн хугацаанд зарлана.
- 4.2 Сонгон шалгаруулалтад оролцох иргэд дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.
  - Сонгон шалгаруулалтанд орох хүсэлт /загварын дагуу/
  - Төрийн албан хаагчийн анкет /1 маягт /
  - Иргэний үнэмлэх, нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар
  - Боловсролын диплом (Бакалавр, магистр, доктор)-ын хуулбар хавсралтын хамт (нотариатаар баталгаажуулсан)

- Мэргэжлийн диплом, үнэмлэхний хуулбар (нотариатаар баталгаажуулсан)
  - Мэргэшүүлэх сургалтанд хамрагдсан диплом, гэрчилгээний хуулбар
  - Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хуулбар
  - 4х6 хэмжээтэй цээж зураг 1 хувь
  - Бусад шаардлагатай холбогдох бусад бичиг баримт
- 4.3 Тухайн ажлын байранд горилогчийн бүрдүүлсэн бичиг баримтыг Хүний нөөц, хөгжлийн алба хүлээн авна.
- 4.4 Албан тушаалын тодорхойлолтод заагдсан ерөнхий шаардлагыг хангаагүй, мэргэжлийн үнэмлэх, дипломгүй, баримт бичиг дутуу ажил горилогчийн материалыг хүлээн авахгүй.

### **Тав. Сонгон шалгаруулах үйл ажиллагаа**

#### 5.1 Сонгон шалгаруулалтад оролцогчдод тавигдах шаардлага:

- 5.1.1. ХСҮТ-д ажиллахыг хүссэн иргэнд тавигдах ерөнхий шаардлага нь ХСҮТ-ийн захирлын тушаалаар батлагдсан сул чөлөөтэй буюу эзгүй ажлын байрны албан тушаалын тодорхойлолтын тавигдах шаардлагаар тодорхойлогдоно.
- 5.1.2. Зарим тохиолдолд тухайн мэргэжлийн онцлогоос хамаарч нэмэгдэл шаардлага тавигдаж болно.
- 5.1.3. Шинээр авч буй ажилтанд тавих нийтлэг шаардлага
- Ажил горилогч нь эрүүгийн хэрэгт болон тухайн мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой зөрчлийн хэрэгт холбогдож байгаагүй байх, өмнө нь ажиллаж байсан байгууллагаас сахилгын шийтгэлээр ажлаас чөлөөлөгдөөгүй байх, мөн эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг зөрчиж ёс зүйн алдаа гаргаж байгаагүй байх
  - Харилцааны ур чадвартай, ачаалал даах чадвартай хамт олны дунд эвсэг нөхөрсөг зан байдлыг эрхэмлэн бусад ажилтнуудтай багаар ажиллаж чаддаг, тэднээс байнга суралцдаг байх;
  - Шинэ мэдээлэл, технологийг эрэлхийлэн, тэдгээрийг дамжуулах биш, ажлын хэрэгцээнд тохируулан боловсруулж, практикт хэрэгжүүлэх талаар бүтээлчээр сэтгэж ажилладаг байх;

#### 5.2 Сонгон шалгаруулах үйл ажиллагааны дараалал:

- 5.2.1 Хүний нөөц, хөгжлийн албанаас сул чөлөөтэй буюу эзгүй ажлын байрны хэрэгцээг төвийн ерөнхий захиралд танилцуулж, сонгон шалгаруулалт явуулах ажлын байрны зарыг нийтийн мэдээллийн хэрэгсэл болон ХСҮТ-ийн [www.cancer-center.gov.mn](http://www.cancer-center.gov.mn) вэб сайт, фэйсбүүк дэхь "Хавдар судлалын үндэсний төв" лэйж хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэнэ. Үүнтэй холбогдох зардлыг ХСҮТ-ийн захиргаа хариуцан гаргана.
- 5.2.2 Энэ журмын 4.2.1-д заасан мэдээлэлд: сул чөлөөтэй буюу эзгүй байгаа орон тооны ажил, албан тушаалын нэр, ажилтнаар ажиллах иргэнд тавигдах мэргэжлийн шаардлага, сонгон шалгаруулалтын болзлыг дурьдах ба ажлын байрны талаар сонирхсон хүмүүст авч ажиллуулах хугацаа, байгуулах хөдөлмөрийн гэрээний төрөл /хугацаатай, туршилтын, контракт г.м./ болон сонгон шалгаруулах журмыг танилцуулж болно.
- 5.2.3 Сонгон шалгаруулалтад орж өрсөлдөх гэж буй иргэдийг урьдчилан тогтоосон хугацаанд бүртгэн авна.